

# ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ЦАХИМ СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

---

## Тавтай морил!

Эрхэм суралцагч та **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай** цахим сургалтанд тавтай морилно уу.

Банк, санхүүгийн байгууллагын ажилтнуудад ажлын байрандаа аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н мэдлэгийг энэхүү сургалтанд хамрагдснаар мэдэж авах боломжтой юм. Сургалтын агуулга нь банк, санхүүгийн салбарын ажилтан бүр заавал мэдэж байвал зохих хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголтуудыг хамарсан. Түүнчлэн энэ хичээлээр аж ахуйн нэгж байгууллагыг “Covid-19” халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх үүднээс тодорхой арга хэмжээнүүд авах, халдвараас сэргийлэх бүх л боломж, үйл ажиллагааг даган мөрдөхөд туслах зорилготой бэлтгэгдсэн болно.

Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь ХАБЭА-н тухай хууль болон НХХЯ-ны А370 тушаалаар баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

## Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, хандлага

1. Хөдөлмөрийн тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаарх ерөнхий мэдлэг;
2. Ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод хүргэж болзошгүй аюулыг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаарх ерөнхий ойлголт;
3. Мэргэжлээс шалтгаалсан өвчлөл үүсгэж болзошгүй ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаарх ерөнхий ойлголт;
4. Ажлын байран дахь осол, өвчлөлд хүргэж болзошгүй хүчин зүйлсийг илрүүлэх, мэдээлэх, арилгах арга хэмжээнд идэвхтэй оролцох хандлага.

## Сургалтын бүтэц, зохион байгуулалтын тухай

Энэхүү сургалт нь цахим хэлбэртэй, 7 хоногийн хугацаанд онлайн сургалтын систем дээр нээлттэй байна. Сургалтын аргачлал нь онол, дадлага хэлбэртэй. Нийт 11 сэдвээс бүрдсэн 4 модуль хичээлтэй үргэлжилэнэ.

Дараагийн хичээлийг судлахын тулд өмнөх хичээлийн шалгалтанд тэнцсэн байх шаардлагатай.

Үүнд:

№	Модулийн бүтэц		Сэдвийн бүтэц		
1	Модуль 1	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бататгал хичээл (видео)</li> <li>✓ Кейс хичээл</li> <li>✓ Модулийн шалгалт</li> </ul>	1.1	ХАБЭА-н тухай ерөнхий ойлголт	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын слайд (аудио&amp;видео&amp;ппт)</li> <li>✓ Сэдвийн мэдлэг шалгах тест</li> </ul>
			1.2	Хөдөлмөрийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын слайд (аудио&amp;видео&amp;ппт)</li> <li>✓ Сэдвийн мэдлэг шалгах тест</li> </ul>
			1.3	ХАБЭА-н тухай хууль	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын слайд (аудио&amp;видео&amp;ппт)</li> <li>✓ Сэдвийн мэдлэг шалгах тест</li> </ul>
2	Модуль 2	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бататгал хичээл (видео)</li> <li>✓ Кейс хичээл</li> <li>✓ Модулийн шалгалт</li> </ul>	2.1	Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын слайд (аудио&amp;видео&amp;ппт)</li> <li>✓ Сэдвийн мэдлэг шалгах тест</li> </ul>
			2.2	Онцгой байдал (Суурь мэдээлэл)	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын слайд (аудио&amp;видео&amp;ппт)</li> <li>✓ Сэдвийн мэдлэг шалгах тест</li> </ul>
3	Модуль 3	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бататгал хичээл (видео)</li> <li>✓ Кейс хичээл</li> <li>✓ Модулийн шалгалт</li> </ul>	3.1	Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн төрлүүд, мэргэжлээс шалтгаалах өвчин (МЦӨ)	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын слайд (аудио&amp;видео&amp;ппт)</li> <li>✓ Сэдвийн мэдлэг шалгах тест</li> </ul>
			3.2	Ажлын хувцас, хувийн	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын слайд (аудио&amp;видео&amp;ппт)</li> </ul>

				хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ	✓ Сэдвийн мэдлэг шалгах тест
			3.3	Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, бууруулж арилгахад ажилтан бүрийн үүрэг, оролцоо	✓ Сургалтын слайд (аудио&видео&ппт) ✓ Сэдвийн мэдлэг шалгах тест
4	Модуль 4	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бататгал хичээл (видео)</li> <li>✓ Кейс хичээл</li> <li>✓ Модулийн шалгалт</li> </ul>	4.1	Ажил эхлүүлэхээс өмнө эрсдлийн үнэлгээ хийх арга	✓ Сургалтын слайд (аудио&видео&ппт) ✓ Сэдвийн мэдлэг шалгах тест
			4.2	Осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж	✓ Сургалтын слайд (аудио&видео&ппт) ✓ Сэдвийн мэдлэг шалгах тест
			4.3	Ажилтны зан үйлтэй холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт	✓ Сургалтын слайд (аудио&видео&ппт) ✓ Сэдвийн мэдлэг шалгах тест

## Сургалтын үр дүн

Сургалтын **сэдэв бүрийн** эцэст оролцогчийн мэдлэг шалгах тестийг 80%-ийн амжилттай гүйцэтгэх шаардлагатай бөгөөд амжилтгүй тохиолдолд давтан өгөх боломжтой. Харин 4 модуль тус бүрийн эцэст шалгалттай, тухайн шалгалтыг (босго оноо болох 80%) 2 удаа үнэ төлбөргүй өгөх эрхтэй. Энэхүү сургалт нь нэгдсэн шалгалтгүй тул оролцогчийн сургалтын үр дүнг 4 модулийн шалгалтын дунджаар тооцно. Шалгалтаа 2 удаа амжилтгүй өгсөн тохиолдолд дахин шалгалтын төлбөр 5,000 төгрөг байна.

Сургалт эхлэхэд **ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ЦАХИМ СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**-ыг заавал уншиж танилцсан байхаас гадна сургалтын төгсгөлд сургалтын талаарх үнэлгээг бүрэн гүйцэд бөглөсөн байна.

Дараах шалгуурыг хангасан оролцогчдод Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтаарх мэдлэгийг эзэмшсэн гэж үзэж Гэрчилгээ олгоно.

Үүнд:

1. Сургалтын бүх сэдвийг судалсан байх;
2. Эзэмшвэл зохих мэдлэгийн 80-аас багагүй хувийг эзэмшсэн нь Модуль тус бүрийн шалгалтын дунджаар үнэлэгдсэн байх.

## Сургалтын гарын авлага, материал

Оролцогч нь орчин нөхцөлөөсөө шалтгаалан сургалтын үндсэн мэдлэг олгох слайдыг ппт<sup>1</sup>, видео болон аудио хэлбэрийн аль нэгийг эсвэл хослуулан сонгож суралцах боломжтой. Сургалтын модуль бүрд мэдлэг бататгаж, хандлага төлөвшүүлэх зорилготой кейс ажил, бататгал видео хичээлийг сургалтын системд байршуулсан. Сургалтанд ашиглагдах материал нь дараах хэлбэртэй байна.

Үүнд:

- ✓ Анимешн, текст бүхий слайдууд
- ✓ Аудио (сонголтоор)
- ✓ Богино хэмжээний видео бичлэг
- ✓ Бататгал хичээл (видео)
- ✓ Кейс ажил - татаж авах боломжтой
- ✓ Нэмэлт унших материалын холбоос линк
- ✓ Сэдвийн тест
- ✓ Модулийн шалгалт

Сургалтын материалын хувьд кейс ажлаас бусад нь татаж авах боломжгүй. Сургалтын онлайн систем рүү ямар ч төхөөрөмжөөс (гар утас, таблет гэх мэт) хандаж болох ба суурин эсвэл зөөврийн компьютероос хандаж сургалтандаа оролцох нь илүү тохиромжтой юм.

---

<sup>1</sup> PowerPoint presentation

### **Сургалтын давтамж**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17.4: Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулан, шалгалт авч байна.

### **Цахим сургалтын талаар холбоо барих**

Онлайн сургалтын системтэй холбоотой асуудал байвал [online@bfa.mn](mailto:online@bfa.mn) болон сургалтын агуулга, тесттэй холбоотой асуудал байвал [helpdesk@bfa.mn](mailto:helpdesk@bfa.mn) хаяг болон 75754848 дугаарын утсанд хандана уу.